



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/30

Аргатай

Газар эзэмших эрхийг
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтууд, Газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Тус сумын Шилийн гол 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт Ол овоо байршилтай 5000м.кв (0.5 га) өвөлжөөний зориулалттай газрын эзэмшигч Ишдовдон овогтой Баянмөнх (ЗБ66101919) өвөлжөө, хаваржааны зориулалтай 5000 м.кв (0.5га) газрыг иргэн Амгаланбаатар овогтой Гандулам (Н392011900)-д зориулалтаар нь шилжүүлж 12 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчийн газрын гэрчилгээг шинэчлэн олгож, газар эзэмших гэрээ байгуулж ажиллахыг Газрын даамал (Т.Шуухааз)-д зөвшөөрсүгэй.

3. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч иргэнд үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/110 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтын 14 дэххэсгийг мөн газар эзэмших эрхийн 0000188969 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ЗОЛЗАЯА

482301074